



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 541

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Замын-Үүд дэх Гаалийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын шаардлага хангахгүй болсон, нийт 246,740,000.00 (хоёр зуун дөчин зургаан сая долоон зуун дөчин мянга) төгрөгийн балансын үнэ, 239,185,120.34 (хоёр зуун гучин есөн сая нэг зуун наян таван мянга нэг зуун хорин төгрөг гучин дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Гаалийн ерөнхий газрын дарга Р.Отгонжаргал, Замын-Үүд дэх Гаалийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Цэенрэгзэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132002406
23-r huraldaan.docx

...ын бодлого, зохицуулалтын газрын 10 дугаар сарын 23-ны өдөр /2019/..... дугаар тогтоолын хавср

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Рентген (Хашаа, зам талбай, манаачийн байр)	2006.06.29	1	ш	246,740,000.00	239,185,120.34	7,554,879.66
Нийт дүн					246,740,000.00	239,185,120.34	7,554,879.66
				(хоёр зуун дөчин зургаан сая долоон зуун дөчин мянга)	(хоёр зуун гучин есөн сая нэг зуун наян таван мянга нэг зуун хорин төгрөг гучин дөрвөн мөнгө)	(хоёр зуун гучин есөн сая нэг зуун наян таван зуун тавин дөрвөн мянга найман зуун далан есөн төгрөг жаран зургаан мөнгө)	(долоон сая таван зуун тавин дөрвөн мянга найман зуун далан есөн төгрөг жаран зургаан мөнгө)

НИЙТ ДҮН